



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1, “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 18/16 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 183 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тус үнэт цаасны компанийн ирүүлсэн саналыг харгалзан гишүүнчлэлийн хөлсийн нийт өр барагдуулах хугацааг 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоож, хугацаат үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ шууд авахыг “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК /С.Гантулга/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын алба /Л.Нямдагва/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР